



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/387

Улаанбаатар хот

Дотоод аудитын албаны бүтэц, орон  
тоонд өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 487 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоол, 2024 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Дотоод аудитын албаны бүтэц, орон тооны дээд хязгаарыг 8 (найм) байхаар хавсралтаар баталсугай.

2. Албан тушаалд өөрчлөлт орсонтой холбогдуулан Төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан ажиллахыг Дотоод аудитын алба (М.Хоролсүрэн)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2022 оны “Дотоод аудитын албаны орон тоо, бүтцэд өөрчлөлт оруулах тухай” А/398 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай .

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

152501-205